



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
З.МЭНДСАЙХАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,
E-mail: info@mird.gov.mn, http://www.mird.gov.mn

2020.03.17 № 03/11.46

гивнай

-ны №

Үнэлгээ хүргүүлэх тухай

"Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" ТӨХХК-ийн захирлын 2018 оны контрактын гэрээний биелэлтийг дүгнэхтэй холбогдуулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өмчийн үйлдвэрийн газар, Төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам"-ын 3.6 дахь заалтын дагуу салбарын яамнаас өгөх үнэлгээг хүргүүлж байна.

"Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" ТӨХХК-д хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 249 дүгээр тушаалаар баталсан "Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ын дагуу 2019 оны жилийн эцсийн байдлаар дүгнэхэд нийт 25 үүрэг даалгавраас өгснөөс 13 үүрэг даалгавар 100%-ийн биелэлттэй, 1 үүрэг даалгавар 30%-ийн биелэлттэй, 11 үүрэг даалгаврын хэрэгжүүлэх хугацаа болоогүй, хэрэгжилт 95% буюу 14,2 оноогоор үнэлэгдлээ.

Үүрэг даалгаврын биелэлтийг хавсаргав.

Хавсралт: 5 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.БАТБОЛД

1118268062 5919487 СБТ9512

**“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ” ТӨХХК-Д
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭР, ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛААР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ**

/2019 оны жилийн эцсийн байдлаар/

№	Эрх зүйн акт, заалт	Хэрэгжилт	Үнэлгээ
Ерөнхийлөгчийн зарлиг			
2019 13. Монгол баатарлаг туульсаа дээдлэн дэлгэрүүлэх тухай			
1	4. Монгол баатарлаг туульсынхаа агуулга, ач холбогдлыг таньж ойлгох, дэмжин дэлгэрүүлэх, өв соёлоо хүндэтгэн дээдлэх, хадгалах, уламжлуулан хамгаалах үйлсэд идэвх санаачлагтай оролцохыг төрийн ба төрийн бус байгууллага, иргэд олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллагуудад уриалсугай.	Монгол туулийг 2009 онд ЮНЕСКО-гоос "Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн дэлхийн жагсаалт"-д бүртгэн тунхагласан байдаг талаар болон Ерөнхийлөгчийн 2019 оны 13 дугаар зарилгийг албан хаагчиддаа мэдээлэл өгч сурталчилж ажиллаа.	100
2	3. Баатарлаг туульсаа дээдлэн хамгаалах, бүртгэн судлах, өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, олон улсад сурталчлан таниулах, туульч, өвлөн уламжлагч, өв тээгчид болон судлаачдыг урамшуулах үйл ажиллагааг дэмжих үйлсэд идэвх санаачлагтай оролцохыг яам болон харьяа агентлаг, байгууллагын дарга, захирал нарт тодорхой арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосон.	Монгол туулийг 2009 онд ЮНЕСКО-гоос "Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн дэлхийн жагсаалт"-д бүртгэн тунхагласан байдаг талаар болон Ерөнхийлөгчийн 2019 оны 13 дугаар зарилгийг албан хаагчиддаа мэдээлэл өгч сурталчилж ажиллаа.	100
Засгийн газрын тогтоол			
2019 оныг "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил" болгох тухай 2019.01.16 №23			
3	3. "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг эрхлэх ажлын хүрээ, харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж, ажлын тайланг улирал тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал үйл ажиллагаа явуулж эхлээгүй болно.	Хугацаа болоогүй
Дүрэм батлах тухай 2019.01.23.№33			
4	2. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал үйл ажиллагаа явуулж эхлээгүй болно.	Хугацаа болоогүй
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл			
5	2. Төрийн болон нутгийн удирдлагын бүх шатны байгууллагууд баталсан дүрэм, журамдаа шинжилгээ хийж, иргэд, олон нийтээр хэлэлцүүлэн, байгууллага, иргэдэд хүнд суртал, чирэгдэл үүсгэж байгаа дүрэм, журмыг хүчингүй болгох арга хэмжээ авч, ЗГХЭГ-т мэдээг, хагас бүтэн жилээр ирүүлэх	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.	Хугацаа болоогүй

6	3.Төрийн байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй төрийн албан хаагч, албан тушаалтанд хариуцлага тооцож, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээнд тусгаж байх	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.
---	---	--

Хугацаа
Боломүй

Засгийн газрын албан даалгавар

Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай
2017.10.26

7	<p>Шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж, төрийн бүх шатны байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас дараах албан даалгаврыг өгч байна:</p> <p>1. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагын дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад:</p> <p>1.1. Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх: Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах;</p>	<p>"Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" -ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 09 дүгээр сарын 04-ны өдрийн А/05 дугаар тушаалаар компанийн ажилчдын "Ёс зүйн дүрэм"-ийг, 2018 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/06 дугаартай тушаалаар Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах албан даалгаврын дагуу хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө"-г батлан мөрдүүлээд байна. Мөн Гүйцэтгэх захирлын 2018 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн А/10 дугаартай тушаалаар "Ёс зүйн хороо"-г томилон ажиллуулж байгаа бөгөөд одоогоор Ёс зүйн хороонд гомдол, санал ирээгүй байна. Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажилтан сонгон шалгаруулж ажилд авах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдөр А/15 дугаартай тушаалаар "Хүний нөөцийн бодлогын баримт бичиг", 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/19 дугаартай тушаалаар "Хүний нөөцийг бүрдүүлэх сонон шалгаруулах журам"-ыг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Мэргэшсэн ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор "Хөдөлмөрийн дотоод журам"-д мэргэшлийн зэргээс хамааран нэмэлт олгохоор тусгасан Мөн Гүйцэтгэх захирлын 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн Б/06 дугаартай тушаалаар цалингийн сүлжээг баталсан бөгөөд ажилтны ажлын тайланг үнэлэх урамшуулал олгох журмын хүрээнд хийсэн ажлын гүйцэтгэл, ур чадварыг харгалзан цалингийн шатлалыг ахиулан ажиллаж байна.</p>	100
8	<p>1.2. Авлигын хяналтыг сайжруулах: Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх;</p>	<p>Гүйцэтгэх захирлын 2018.09.04-ний өдрийн А/05 дугаартай тушаалаар Компанийн "Ёс зүйн дүрэм"-ийг батлан мөрдүүлсэн бөгөөд уг дүрмийн 5.1.4-д ажилтан албан үүргээ гүйцэтгэсэн болон гүйцэтгээгүйн улмаас ашиг сонирхол нь хөндөгдөх дотоод гадаадын аливаа иргэйн хуулийн этгээдэд давуу байдал олгох, тэдэнтэй үгсэн тохирол, амлалт өгөх, тэднээс шан харамж хөнгөлөлттэй</p>	100

		<p>үйлчилгээ, зээл авах, хууль бус бусад шан харамж эдлэхгүй байх талаар тусгасан.</p> <p>Мөн 2018.09.04-ний өдрийн А/06 дугаартай тушаалаар Монгол Улсын Засгийн газрын 2017.10.26-ны өдрийн 01 дугаартай албан даалгавар, ЗТХС-ын 2017.11.20-ны өдрийн 02 дугаартай албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан мөрдүүлэн ажиллаж байна.</p> <p>Компанийн бүхий л үйл ажиллагаанд ил тод нээлттэй байх зарчмыг баримтлан ажилтан шинээр авах, худалдан авах ажиллагаа хийх бүрт компанийн вэб сайтад байрлуулахаар холбогдох дүрэм журмыг боловсруулан батлаад байна</p> <p>Лүйцэтгэх захирлын 2018.10.12-ны өдрийн А/15 дугаартай тушаалаар "Хүний нөөцийн бодлогын баримт бичиг", 2018.12.03-ны өдрийн А/19 дугаартай тушаалаар "Хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах журам"-ыг боловсруулан мөрдүүлээд байна.</p> <p>Компанийн нийт ажилтнууд хүнд сурталгүй байх зорилгоор вэб сайтад online Туслах булан ажиллуулж иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлэх өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд цаг тухай бүр хариу өгч ажиллаж байна.</p> <p>Компанийн "Ёс зүйн дүрэм"-д шударга ёсны зарчмыг тусгайлан тусгасан бөгөөд ёс зүйн дүрмийн зөрчил нь ажилтныг ажлаас чөлөөлөх үндэслэл байхаар Хөдөлмөрийн дотоод журамд тусган хариуцлагын тогтолцоог бүрдүүлээд байна. Мөн Гүйцэтгэх захирлын 2018.10.01-ний өдрийн А/12 дуаартай тушаалаар Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ажилтнуудыг мэдээ мэдээллээр хангах ЭБАТ-ыг томилон ажиллуулж байна. 2018.12.24-ний өдөр АТГ-аас зохион байгуулсан сургалтад Компанийн ЭБАТ болон зарим ажилчдыг хамруулсан болно.</p>	
9	1.3. Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх: "Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв"-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах;	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.	Хугацаа болоогүй

10	1.4. Төрийн албаны үр ашгийг сайжруулах: Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих;	Ажлын цагийн бүртгэлийг тусгай төхөөрөмжийн дагуу бүртгэж, бүртгэлийн мэдээллийг цахим хэлбэрт оруулсан. Ажлын цаг ашиглалттай холбоотой дутагдал гаргасан ажилтанд хариуцлага тооцох тухай зохицуулалтыг "Хөдөлмөрийн дотоод журам", Ёс зүйн дүрмэнд оруулан баталсан.	100
11	1.5. Бодлогын тогтвортой байдлыг хангах: Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх.	Ажилтнуудыг мэргэшүүлэн, тогтвор суурьшилтай ажиллуулах, хүний нөөцийн бодлогыг тогтвортой байлгах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2018.10.12-ны өдрийн А/15 дугаартай тушаалаар "Хүний нөөцийн бодлогын баримт бичиг", 2018.12.03-ны өдрийн А/19 дугаартай тушаалаар "Хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах журам", 2018.12.03-ны өдрийн А/20 дугаартай тушаалаар "Ажлын гүйцэтгэлийг тайлагнах дүгнэх, урамшуулал олгох, хариуцлага тооцох журам"-ыг боловсруулан мөрдүүлээд байна. Эдгээр журмын хүрээнд ажилтан сонгон шалгаруулах зарыг нээлттэй ил тод байдлаар зарлаж, ажилтны ажлын тайланг журамд заасан хугацаанд гаргуулан үнэлэлт дүгнэлт өгч ажиллаж байна. Мөн албан тушаал ахих тогтолцоог мерит зарчимд үндэслэхээр журамд тусгасан болно.	100
12	2.1. Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдүүлж ажиллах;	Гүйцэтгэх захирлын 2018 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/06 дугаартай тушаалаар "Шуурхай ажлын үед хэрэгжүүлэх журам"-ыг батлан мөрдөж байна. Мөн тус компани нь өдөр тутмын үйл ажиллагаагаа зохион байгуулалттай, шуурхай явуулах зорилгоор 7 хоног тутам хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг тухайн 7 хоногийн эхэнд гарган, Гүйцэтгэх захирлаар батлуулж хэрэгжилтийн явц үр дүнг 7 хоног тутмын "Захирлын шуурхай хурал"-аар хэлэлцэж, шийдвэрлэн ажиллаж байна. Ажилтнуудын 7 хоногийн ажлын төлөвлөгөөнд хийх ажлаа тусгаснаар ажлын бүтээмж, сахилга хариуцлагыг өндөржүүлж, өгсөн үүрэг даалгавар, төлөвлөгөөт ажлын биелэлтийг тогтмол хянах боломжтойгоор зохион байгуулж байна.	100
13	2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, хууль тогтоомжид заасан лиценз болон бусад тусгай зөвшөөрөл, газар олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй болгон зохион байгуулж ажиллах;	"Хөшигийн хөнгийн нисэх онгоцны буудал" ТӨХХК нь 2018 нийт 7 худалдан авалт хийсэн бөгөөд тэдгээрээс нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 1, харьцуулалтын аргаар 3, шууд гэрээ байгуулах аргаар 3 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан болно. Худалдан авалтуудтай холбоотой гомдол санал гараагүй бөгөөд хуульд заасан	100

		журам, шаардлагын дагуу үнэлгээний хороо байгуулж ажилласан. Харин 2019 онд худалдан авах ажиллагаа хийгдээгүй. Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" ТӨХХК-д холбогдох хууль тогтоомжоор лиценз, тусгай зөвшөөрөл болон газар олгох эрх олгогдоогүй буюу эдгээрийг бусдад олгодоггүй болно	
14	2.3. Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх;	Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд шилэн дансны мэдээллийг цаг тухай бүр оруулж ажиллаж байна. Мөн төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах бүртээ ил тод байдлыг ханган ажиллаж байгаа бөгөөд компанийн үйл ажиллагааг нээлттэй байлгах, мэдээ мэдээллийг цаг тухай бүр олон нийтэд хүргэж байх зорилгоор компанийн вэб сайтыг ажиллуулж байна. Мөн Компанид хандаж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагын өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд цаг тухай бүр хүнд сурталгүйгээр хариу өгч байх зорилгоор компанийн вэб сайтад online Туслах булан ажиллуулж байна. Компанийн сайн засаглалыг хөгжүүлэх зорилгоор одоогийн байдлаар нийт 14 дүрэм, журам боловсруулан мөрдүүлээд байна. Үүний дотоо Ёс зүйн дүрэм мөн орно.	100
15	2.4. Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр нь хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх;	Гүйцэтгэх захирлын 2018 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/01 дугаартай тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам", 2018 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/05 дугаартай тушаалаар батлагдсан "Ёс зүйн дүрэм"-д хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр нь авах арга хэмжээний тухай тодорхой тусгасан болно. Одоогийн /2019.04.04/ байдлаар ямар нэг зөрчил дутагдал гараагүй байгаа болно.	100
16	2.5. Удирдлага, ажилтнуудын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбож ажиллах.	Нэгж, ажилтны ажлын үр дүнг 2019 оны IV улирлаар үнэлж дүгнэн Захирлын 2019.03.28-ны өдрийн А/13 дугаар тушаалаар 21 ажилтанд, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж батлуулах ажилд үр бүтээлтэй оролцсон 6 ажилтан Захирлын 2019.05.21-ний өдрийн А/21 дүгээр тушаалаар тус тус урамшуулал олгосон.	100
17	3. Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар, үр дүнг дээшлүүлж төсвийн үргүй зардлыг багасган хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, хэмнэлтийн горимыг чанд сахин ажиллахыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж байна.	Тус компанийн орон тоо нийт 27 хүний бүрэлдэхүүнтэйгээр батлагдсан хэдий ч төсвийг хэмнэх зорилгоор одоогийн байдлаар 8 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. "Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал"	100

		<p>ТӨХХК нь 2018 нийт 7 худалдан авалт хийсэн бөгөөд тэдгээрээс нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 1, харьцуулалтын аргаар 3, шууд гэрээ байгуулах аргаар 3 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан болно. Худалдан авалтуудтай холбоотой гомдол санал гараагүй бөгөөд хуульд заасан журам, шаардлагын дагуу үнэлгээний хороо байгуулж ажилласан.</p> <p>Харин 2019 онд худалдан авах ажиллагаа хийгдээгүй байгаа болно. Мөн компанаас гарч буй урсгал зардлыг хэмнэх зорилгоор компанийн автомашиныг шаардлагтайгаас бусад тохиолдолд хэрэглэхгүй байж шатахууны хэмнэлт хийж ажиллаж байна.</p>	
Сайдын тушаал			
<p>Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2019.07.26 №253 дугаар тушаал</p>			
18	1.2. Эрүүл мэндийн үзлэгт зайлшгүй хамруулах шаардлагатай ажилтныг зохих журмын дагуу үзлэгт хамруулан, үзлэгийн мөрөөр эрүүл мэндийг хамгаалж, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулан, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлж, ажилтанд учирч болох эрсдлээс хамгаалсан байх;	"Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" ТӨХХК нь 2019.12.13-ны өдрийн байдлаар 11 ажилтантай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр нь ажилтнууд нь эрүүл мэндийн үзлэгт зайлшгүй хамруулах шаардлагагүй боловч 2020 оны төсөв батлагдах үед холбогдох арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	Хугацаа болоогүй
19	1.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комиссын ажлын явц, осолд дөхсөн тохиолдол, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан нөхцлийг тодруулж, холбогдох арга хэмжээг авч, ажилтнуудын ажил үүргийн хувиарлалт, ажил амралтын дэглэмийг мөрдүүлж, осол зөрчлөөс урьдчилан сэргийлж ажилласан байх;	"Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК, Үндэсний хөгжлийн газрын хооронд байгуулсан Концессын гэрээ 2019.09.01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон бөгөөд Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын үйл ажиллагаа 2020.07.01-ний өдрөөс эхлэхээр төлөвлөөд байна. Иймд "Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" ТӨХХК нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комиссы байгуулаагүй байна. нисэх онгоцны шинэ буудлыг ашиглалтад орох үед холбогдох дүрэм журамд нэмэлт өөрчлөлт оруулах болон зохион байгуулах журмыг батлан мөрдүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	Хугацаа болоогүй
20	1.4. Ажилтны ажлын нөхцөл, онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр ханган, ажилтнуудад бүрэн ашиглуулж, тэдгээрийн хадгалалт, угаалга, цэвэрлэгээ, засвар, ариутгалыг хариуцаж, аюултай, хортой нөхцөлд ажилладаг ажилтныг хүнсний бүтээгдэхүүн, хор саармагжуулах бодисоор хангаж, ажил, үйлчилгээний явцад үүсэх хими,	Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын үйл ажиллагаа эхлээгүй байгаатай холбоотойгоор "Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" ТӨХХК-ийн ажилчид тусгай хамгаалах хувцас хэрэглэх шаардлагагүй байгаа болно. Мөн одоогоор хортой нөхцөлд ажилладаг ажилтан байхгүй байна. 2020 онд нисэх онгоцны шинэ	Хугацаа болоогүй

	физик, биологийн хүчин зүйл нь ажилтны эрүүл мэндэд сөрөгөөр нөлөөлж байгаа тохиолдолд багасгаж, бууруулсан байх;	буудал үйл ажиллагаа эхлүүлэхэд ХХНОБ нь ВИП заалны үйлчилгээг хариуцах бөгөөд тухайн үед холбогдох ажилчдыг ажлын хувцсаар хангахаар 2020 оны төсвийн төсөлд тусгаад байна.	
21	1.5. Ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохих сургалтад хамруулж, шалгалт авч, "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Сургалтын зохион байгуулалт. Үндсэн дүрэм" MNS 4969:2000 үндэсний стандартын дагуу аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажлын байрны онцлогт тохируулан тогтмол өгч, эрүүл, аюулгүй нөхцөлд ажиллах дэдлэг ажилтан бүрт эзэмшүүлсэн байх;	Компанийн санхүүгийн байдал хүндрэлтэй байгаатай холбоотой, болон Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын үйл ажиллагаа эхлээгүй байгаатай холбоотойгоор батлагдсан бүтэцийн орон тоог бүрэн бүрэлдээхүүнээрээ ажиллаж эхлээгүй байна. Орон тоо бүрдсэн үед буюу 2020 оны 1 дүгээр улиралд холбогдох сургалтуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.	Хугацаа болоогүй
22	1.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг жил бүр төсөвт тусган зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд хяналт тавих;	Компанийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтод түвшинд тусгасан бөгөөд 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтод түвшингийн төсөлд тусгаад байна. 2020 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтод түвшинг батлах Хувьцаа эзэмшигчдийн хурал хийгдээгүй байна.	Хугацаа болоогүй
23	1.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдсэн үзлэг, хяналт, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, түүний хэрэгжилтэд хяналт тавьж зөрчил дутагдлыг арилгуулсан байх;	Дээд газраас ирүүлсэн үүрэг даалгаврыг холбогдох тайлбарын хамт заасан хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар ямар нэг зөрчил дутагдал гараагүй байна.	Хугацаа болоогүй
24	2. Энэхүү тушаалын 1 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван /3/ шатны хяналтыг зохион байгуулах журам"-ыг боловсруулан баталж, хэрэгжилтийг хагас жил тутамд Зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороонд тайлагнаж байхыг харья байгууллагын дарга, удирдлагад үүрэг болгосугай.	"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван шатны хяналтыг зохион байгуулах журам"-ыг боловсруулж батлуулсан.	100
Ажлын хэсэг байгуулах тухай 2019.12.02 №363			
25	1. "Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" ТӨХХК болон Монгол Улсад бүртгэлтэй "Жапан эйрпорт менежмент" ХХК хооронд байгуулсан хувьцаа эзэмшигчийн гэрээний хэрэгжилтийг хангуулах, "Нью Улаанбаатар Интэрнэйшнл Эйрпорт" ХХК-ний удирдлагын зүгээс Монгол Улсын Ерөнхий сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд нарт хандан ирүүлсэн асуудлаар нэгдсэн ойлголцолд хүрэх, "Нью Улаанбаатар Интэрнэйшнл Эйрпорт" ХХК-ний удирдлагын бүтцэд монголын талын төлөөлөлтэй болгох зорилгоор хувьцаа эзэмшигчийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг гүйцэтгэх ажлын хэсэг	Ажлын хэсгийн хурал 2019.12.16-ны өдөр бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдаж, Удирдамжид заасан ажлын чиглэл тус бүрээр асуудлыг шийдэж холбогдох хууль, эрх зүйн үндэслэл, тайлбар материалыг бүрдүүлэн 2019.12.19-ний өдөр дахин хуралдаж уг хуралд танилцуулахаар шийдсэн бөгөөд 2019.12.20-ны өдөр дотор "Жапан эйрпорт менежмент" ХХК-тай уулзалт зохион байгуулахаар шийдвэрлэсэн болно.	30

		Ажлын хэсэг нь удирдамжийн дагуу "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн удирдлагын бүтцэд Монголын талын төлөөлөлтэй болох, тус компани нь төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болох эсэх, Хувьцаа эзэмшигчдийн гэрээний хэрэгжилтийг хангаж харилцан эрх тэгш байх зарчмыг уг гэрээнд нэмж тусгуулах талаар хөлбогдох уулзалт, арга хэмжээг тухай бүр авч Зам, тээврийн хөгжлийн сайдыг мэдээллээр ханган ажиллаж байна.	
Нийт			95%